

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 06-ны өдөр

№ 22

Улаанбаатар хот


Данс нээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, "Сэндли ББСБ" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сэндли ББСБ" ХК нь 2026 онд БНСУ-ын хөрөнгийн зах зээлд Бонд гаргах болон бусад төлөвлөгөөт ажлын хүрээнд компанийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор БНСУ дахь арилжааны банканд вонын данс нээхээр тогтсугай.
2. Данс нээхтэй холбоотой шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх, холбогдох баримт бичигт компанийг төлөөлж гарын үсэг зурах, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд компани төлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.
3. БНСУ-д данс нээхтэй холбоотойгоор шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх захирал өөрт олгогдсон эрхийг итгэмжлэлийн үндсэн дээр "Сэндли Монголиа" ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Цацрал)-д шилжүүлж болохыг дурдсугай.
4. Энэхүү тогтоолын 3-д дурдсан гуравдагч этгээдэд итгэмжлэн олгох үйлдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ





Итгэмжлэл олгох үйлдлийн жагсаалт

1. БНСУ-н Банканд Сэндли ББСБ ХК-ийн мэдээллийг гаргаж өгөх;
2. БНСУ-ын арилжааны банканд компанийн нэр дээр данс нээх, харилцах дансанд орлого зарлагын гүйлгээ хийх;
3. Дансны хуулга гаргуулах, дансны үлдэгдлийн тодорхойлолт гаргуулах зэрэг шаардлагатай баримт бичиг авах хүсэлт гаргах, хүлээн авах;
4. Холбогдох хавсралт баримт бичгийг бүрдүүлж өгөх;
5. Хөрөнгө төвлөрсний дараа Монгол улс руу хууль ёсны дагуу хөрөнгийг шилжүүлэхэд шаардлагатай банк хоорондын төлбөр тооцооны ажиллагаанд оролцох, хүсэлт гаргах, гүйлгээг баталгаажуулах;
6. Бондын хөрөнгө оруулалтаар төвлөрсөн мөнгөн дүнгээс хүүгийн төлбөрийг холбогдох хугацаанд хөрөнгө оруулагчдын дансанд шилжүүлэх, уг гүйлгээтэй холбоотой банк хоорондын төлбөр тооцооны ажиллагаанд оролцох, шаардлагатай баримт бичигт гарын үсэг зурах, хүсэлт гаргах;
7. Бондын хөрөнгөтэй холбоотой банкны баримт бичиг, шилжүүлгийн тайлан, дансны хуулга, тодорхойлолтыг хүлээн авах, баталгаажуулах;
8. БНСУ-д данс нээхтэй холбогдуулан шаардлагатай бол эрх олгосон итгэмжлэлийн хүрээнд БНСУ-н өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн байгууллага эсхүл хувь хүнээс туслалцаа авах;

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 06-ны өдөр

№ 23

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, Сэндли ББСБ ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь “Хайпэй” ХХК-тай нэг сарын 10,420,000 (арван сая дөрвөн зуун хорин мянга) төгрөгийн “Үйлчилгээ үзүүлэх гэрээ” буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийг 2 жилийн хугацаагаатайгаар байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-р дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 06-ны өдөр

№ 24

Улаанбаатар хот

Аудитын байгууллага сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Сэндли ББСБ (цаашид “Компани” гэх) ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь “Далайван Аудит” ХХК-ийг компанийн 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах байгууллагаар сонгосугай.
2. Энэхүү тогтоолын дагуу “Далайван Аудит” ХХК-тай холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах, гэрээний үнийг тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

